




“ДАРХАН ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“ДХББЗГ” ОНӨААТҮГ
2024.12.31






2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ



Нийт 233,0 тэрбум төгрөгийн 151 төсөл, арга
ХЭМЖЭЭ



2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (Салбараар нь авч үзвэл)



Нийт 233.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 151 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй.

2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг 2024 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 2023-2024 онд шилжин хэрэгжиж буй **85.6** тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий **45** төсөл арга хэмжээ, 2024 онд шинээр гэрээ байгуулан хэрэгжиж байгаа 184.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **176** төсөл, арга хэмжээ буюу нийт 270.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **221** төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг хэрэгжүүлж ажиллалаа.






2024 ОНД ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ САЛБАРААР НЬ АВЧ ҮЗВЭЛ

(жилийн эцсийн байдлаар)

Салбар	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	Байнгын ашиглалтад орсон төсөл	2025 онд шилжин хэрэгжих төсөл
Барилга угсралт, засвар, шинэчлэлт, тохижилт	97	120.2 тэрбум төгрөг	78	19
Авто зам, замын байгууламж	80	93.0 тэрбум төгрөг	66	14
Инженерийн шугам сүлжээ	29	33.3 тэрбум төгрөг	20	9
Цахилгаан хангамж, гэрэлтүүлэг	15	23.9 тэрбум төг	9	6
Нийт	221	270.6 тэрбум төг	173	48

2024 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төрлөөр ангилж үзвэл

2024 онд хяналт хэрэгжүүлсэн төслийн
тоо /хөрөнгийн эх үүсвэрээр/



1. Улсын төсвийн 234.5 тэрбум төгрөгийн 57 төсөл, арга хэмжээ
2. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 10,3 тэрбум төгрөгийн 1 төсөл арга хэмжээ
3. Орон нутгийн төсвийн 9.8 тэрбум төгрөгийн 76 төсөл, арга хэмжээ
4. Орон нутгийн хөгжлийн сангийн 12.3 тэрбум төгрөгийн 70 төсөл, арга хэмжээ
5. Замын сангийн 1,3 тэрбум төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ
6. Засаг даргын нөөц хөрөнгийн 73.2 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ
7. Бусад эх үүсвэрийн 2.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 төсөл арга хэмжээ
/Монгол банк, УБТЗ, ХХААХҮЯ, Дархан сумын ЗДТГ, Эрүүл мэндийн газар, Гаалийн ерөнхий газар/



Техникийн хяналт хэрэгжүүлсэн байдал

2024 он 12 дугаар сарын 31

№	АЖЛЫН НЭР	ТОО ХЭМЖЭЭ
1	ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОО	221
2	ТӨСӨВТ ӨРТӨГ	270.6 тэрбум төг
3	БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ЯВЦАД ГАРСАН АЛДААГ ЗАЛРУУЛАХ, ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР ЗӨВЛӨМЖ	1019
4	БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЛАБОРАТОРИЙН СОРИЛ, ШИНЖИЛГЭЭ, ТУРШИЛТ ТОХИРУУЛГА	504
5	ҮЕ ШАТНЫ АЖЛУУДЫГ ХЭМЖИЛТ ХИЙЖ, БАТАЛГААЖУУЛСАН ИЛ ДАЛД АЖЛЫН АКТ	904
6	ФОТО ЗУРГААР БАРИМТЖУУЛСАН БАЙДАЛ	6008 зураг
7	АВТО ЗАМЫН НЯГТЫН ХЭМЖИЛТ	750 цэг
8	ГЕОДЕЗИЙН ХЭМЖИЛТ ХИЙСЭН ЦЭГ	850 цэг
9	ГҮЙЦЭТГЭЛ ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН ТОО	335 удаа
10	2024 ОНД САНХҮҮЖИЛТ БАТАЛСАН ДҮН	103.5тэрбум төг



Төсвийн хэмнэлт үүсгэсэн байдал

2024 он 12 дугаар сарын 31

№	АЖЛЫН НЭР	ТОО ХЭМЖЭЭ
1	Магадлашгүй ажлын зардлаас хасаж тооцсон дүн	173.3 сая төгрөг
2	Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг хангаж хийгдээгүй ажлын зардлаас хасаж тооцсон дүн	86.0 сая төгрөг
3	Зураг төсөл, зохиогчийн хяналтын зардлаас хасаж тооцсон дүн	4.4 сая төгрөг
4	НӨАТ	39.7 сая төгрөг
5	Нийт	303.6 сая төгрөг

ИНЖЕНЕРҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА




- ✓ Инженерүүд өглөө бүр ХАБЭА зааварчилгаа аван ажилдаа гарч байна.
- ✓ Сар бүр төлөвлөгөө боловсруулан ерөнхий инженерээр батлуулан төлөвлөгөөний дагуу хяналт хэрэгжүүлэн ажиллаж байна.
- ✓ Талбай дээр техникийн хяналт хийхдээ барилга угсралтын тэмдэглэлийн дэвтэрт үүрэг даалгавар өгч биелэлтийг хянан ажиллаж байна.
- ✓ Гэрээт хугацаанд багтахгүй, ажил удаашралтай, засварлах шаардлагатай, үүрэг даалгавар биелүүлэхгүй зэрэг компаниудад албан бичгээр шаардлага хүргүүлэн ажиллаж байгаа ба ерөнхий захиалагчид албан бичгээр мэдэгдэж байна.
- ✓ Геодезийн хэмжилтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж байна.
- ✓ Асуудалтай ажлуудад захиалагч, зураг зохиогч, гүйцэтгэгчтэй хуралдаж шийдвэрлэн ажиллаж байна.
- ✓ Ил тод байдлын хүрээнд байгууллагын фэйсбүүк фэйж хуудсанд төсөл, арга хэмжээний ажлын явцын мэдээ, мэдээллийг тогтмол байршуулж байна.



Долоо хоног бүрийн мягмар гаригт Дархан-Уул аймагт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлуудын ажлын явцыг илтгэл хэлбэрээр аймгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хуралд танилцуулж холбогдох шийдвэрийг хурлын тэмдэглэлээр баталгаажуулан гаргасан. 2024 онд нийт 36 удаа хуралдсан үзүүлэлттэй байна.



7 хоног бүрийн даваа гаригт ИТА, албан хаагчид ээлжлэн сонирхолтой сэдвээр, эсвэл харилцаа хандлага, багийн ажиллагааны талаар сургалт зохион байгуулж байна. Нийт 2024 онд 37 удаагийн дотоод сургалтыг зохион байгууллаа.





Инженерүүдийн мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх зорилгоор сургалт, семинар, барилгын материалын үзэсгэлэнд шат дараалан хамруулан ажиллаж байна.






Албан бичиг шийдвэрлэлт

2024 оны жилийн эцсийн байдлаар байдлаар байгууллага, иргэдээс 1050 албан бичгийг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэж ажилласан ба 937 албан бичгийг холбогдох албан байгууллагууд руу хүргүүлэн ажилласан байна.

Гүйцэтгэлийн бичиг баримтыг баталгаажуулан албан бичгээр захиалагчид хүргүүлж байгаа ба комисс ажиллуулах материалыг гүйцэтгэгчээс нэг бүрчлэн шалган хүлээн авч захиалагчийн нэгдсэн дүгнэлт үйлдэн ерөнхий захиалагчид хүргүүлэн ажиллаж байна.

Хууль тогтоомжийг үндэслэл болгон газрын дарга нь А тушаал 140ш, Б тушаал 69ш гарган үйл ажиллагаандаа мөрдүүлэн ажиллалаа.





Мэдээллийн ил тод байдал

Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар
Нийтэлсэн: Narangarav Alгаа
1h · 0

#Бүтээн_байгуулалт_2024

- 📍 Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Дархан-Уул аймаг, Дархан сум, Гэрэлтэй өрхийн эмнэлэг/
- ✅ Байршил : Дархан сум, 9 дүгээр баг
- ✅ Хүчин чадал : Тэнхлэгээрээ 19,5м х 12,5м зоорьгүй 2 давхар барилга
- ✅ Захиалагч: Дархан-Уул аймгийн ЗДТГ
- ✅ Зураг төсөв зохиогч: "Авто хад" ХОХ
- ✅ Гүйцэтгэгч: "Хангай бигар" ХОХ
- ✅ Эх үүсвэр:УТХО
- ✅ Ажлын гүйцэтгэлийн явц: 30%
- 🔴 2 давхарын бетон цутгалтын ажил 100%
- 🔴 Хэв хашмал хууламтын ажил хийгдэж байна.
- ✅ Хяналтын инженерийн зүгээс өгсөн үүрэг даалгавар: ХАБЭА мөрдөж ажиллах.

Статистик, зарыг үзэх

Сурталчлах

3

3 удаа хуваалцсан

“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” фэйсбүүк цахим хуудсаар дамжуулан Дархан-Уул аймагт 2024 онд улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа барилга угсралт, авто зам, замын байгууламж, инженерийн шугам сүлжээ, гэрэлтүүлгийн төслийн ажлын явцын мэдээ, мэдээлэл болон ажилтан сонгон шалгаруулах зарыг бичмэл, зурган болон видео бичлэг хэлбэрээр 251 удаа олон нийтэд байршуулсан байна. Тус хуудасны мэдээ, мэдээлэл нь 92,103 хүнд хүрч 1212 хүн таалагдсан товчийг дарж, 757 удаа өөрийн цахим хуудаснаа олон нийтэд хуваалцжээ. 43 хүн сэтгэгдэл бичиж 1916хүн дагасан үзүүлэлттэй байна.



2024 оны орлогын төлөвлөгөө, биелэлт



Орлогын
төлөвлөгөө

950.0 сая
төгрөг

Орлогын
Биелэлт

950.0 сая
төг

Аймгийн төсөвт
төвлөрүүлсэн
орлого /2023 онд/

133,6 сая
төг

Дүгнэлт

2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр **233,0** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **151** төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхээс 2024 оны жилийн эцсийн байдлаар байдлаар **270.6** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **221** төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэн ажиллаж, байнгын ашиглалтад **173** төслийг хүлээлгэн өгсөн байна. **48** төсөл арга хэмжээ 2025 онд шилжин хэрэгжинэ.

